

“АРВИЖИХ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 4 дүгээр сарын 29-ны өдөр

№ХЭХ23/01

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны санхүүгийн болон
үйл ажиллагааны тайлан батлах тухай

Арвижих ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дугаар Т23/02 шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2022 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тухай ТУЗ-ийн гүйцэтгэх удирдлагын гаргасан тайланг хангалттай гэж үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА  /Д.БААТАР/



“АРВИЖИХ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр
хот

№ ХЭХ23/02

Улаанбаатар

Компанийн 2022 оны санхүүгийн тайланд
хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийн
тухай

Арвижих ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн
хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дугаар Т23/02 шийдвэрийг үндэслэн
ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2022 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг
хангалттай гэж үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



/Д.БААТАР/

“АРВИЖИХ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ХЭХ 23/03

Улаанбаатар хот

Ногдол ашиг тараахгүй тухай ТУЗ-ийн
шийдвэрийн тухай

Арвижих ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын тооллогын комиссын дугаар Т23/02 шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компани нь 2022 онд орлого олох үйл ажиллагаа явуулаагүй, алдагдалтай ажилласан нь санхүүгийн тайланд тусгагдсанг үндэслэн гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хангалттай гэж үзсүгэй.


ХУРЛЫН ДАРГА  /Д.БААТАР/

“АРВИЖИХ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ХЭХ23/04

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны үйл ажиллагааны
төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын “Компанийн тухай” хуулийн 62 дугаар зүйлийн 1.7-р заалт, 75 дугаар зүйл 4-р заалт, 81 дүгээр зүйлийн 2-р заалт болон Арвижих ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын тооллогын комиссын дугаар Т23/02 шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. 2023 онд компанийн бизнесийн үйл ажиллагааг сэргээх боломж бололцоог судалж боловсруулсан төлөвлөгөө дагуу ажиллахыг ТУЗ-д даалгасугай.


ХУРЛЫН ДАРГА  /Д.БААТАР/

“АРВИЖИХ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ХЭХ23/05

Улаанбаатар хот

Их хэмжээний хэлцэлийн тухай

“Арвижих” Хувьцаат компани (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 сарын 29-ний өдрийн хурлын тооллогын комиссын Т23/02 дугаар шийдвэр, хурлын протокол, Иргэний хуулийн 62 дугаар зүйл, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, 83 дугаар зүйлийн 83.8 дахь хэсэг, 87 дугаар зүйл, Компанийн дүрмийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2023 онд хэрэгжүүлэх, төсөл, үйл ажиллагааны төлөвлөгөөг Хавсралт№1-аар баталсугай.
2. Компанийн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төслүүд, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор шаардлагатай бусад этгээдээс хөрөнгө оруулалт, зээл болон санхүүжилт татан төвлөрүүлэх, Компанийн эзэмшлийн Нийслэлийн засаг даргын 2016 оны А/308 тоот шийдвэрийн дагуу Баянгол дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт олгогдсон 51134 м² талбай бүхий газар дээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтран ажиллах, зээлийн барьцаанд тавих, энэхүү тогтоолд дурдсан аливаа асуудлаар бусад этгээдтэй их хэмжээний болон бусад ямарваа гэрээ хэлцэл байгуулах, гэрээ хэлцлийн нөхцлийг тохиролцох, тэдгээрт Компанийг төлөөлж гарын үсэг зурж баталгаажуулах, нотариатаар гэрчлүүлэх зэрэг энэхүү шийдвэрт дурдсан зорилгыг хэрэгжүүлэхтэй холбоотой, шаардлагатай, тохиромжтой, зөв гэж үзсэн аливаа үйлдэл хийх эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал /Б.Содбаяр/-д итгэмжлэн олгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.БААТАР